

III

Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй

ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХУРААНГУЙ

Х.Сэлэнгэ

*МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн
захирал, хууль зүйн доктор, профессор*

І ОРШИЛ

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б. Чимидийн “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” номын үндсэн агуулга, амин сүнс нь “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гуравдугаар бүлэгт бичигдсэн байна.

“Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” номын “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гуравдугаар бүлэгт Монгол Улсын төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, төрийн байгуулал, төрийн байгууламж, төр ба иргэн, хүний эрхийн тухай Үндсэн хуулийн үзэл баримтлал бүхэлдээ агуулагдсан байх тул зохиогчийн хэлсэнчлэн “алганд багтсан Монгол Улс”-ын шинэ үзэл баримтлал илэрхийлэгджээ.

Монгол Улсын Үндсэн хууль нь либерал онолд үндэслэгдсэн бөгөөд өмнөх Үндсэн хуулиуд болон бусад улс орнуудын Үндсэн хуулиудаас онцлог ялгаатай байна.

“Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” нь зохиогчийн хэлсэнчлэн “сав нь их, санаа нь шавхагдашгүй”

ажээ. Иймд “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гэж нэрлэгдэж байгаа ч, энэхүү бүлгийн үг, өгүүлбэр бүр ихээхэн утга санааг илэрхийлж, Үндсэн хуулийг зөв ойлгож, хэрэгжүүлэхэд их чухал үнэ цэнэтэй байна.

“Үндсэн хуулийн үзэл баримтлал бол бусад хуулийг зөв боловсруулж, ойлгож, хэрэглэхийн анхдагч түлхүүр”¹ тул хууль зүйн ач холбогдолтой юм.

Үндсэн хуулийн үзэл баримтлалыг зөв ойлгож, хэрэгжүүлэх нь Үндсэн хуулиас илүүтэй, түүнийг танин мэдэж хэрэгжүүлэх субъектээс илүүтэй хамаарна. Иймд зохиогчийн үзсэнчлэн, хуулийг санаатайгаар амин хувийн, атгаг санааны үүднээс гуйвуулан, хуулийн зүйл заалтыг өөрчлөн халахаас сэргийлж, хуулийг зөвөөр ойлгож, ёсчлон биелүүлж, оновчтой хэрэгжүүлэх нь Монгол түмний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хуулийн үр шимийг хүртэхэд ихээхэн ач холбогдолтой болно.

“Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” номын “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гуравдугаар бүлгийг судлан дүн шинжилгээ хийхдээ Үндсэн хуулийн эрх зүйн онолд үндэслэн, герменевтик арга зүйг ашиглав. Бүтээлийг судлах явцад герменевтик арга зүйг хэрэглэхэд зохиогчийн үзэл санаа нь бүтээлийн үг, өгүүлбэр бүрт шингэсэн байх бөгөөд энэ нь Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тодорхойлж байх тул бүтээлийг зарим тохиолдолд хуулбарлахаас өөр аргагүй байдалд хүргэж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Нөгөө талаар зохиогч нь 1992 оны Үндсэн хуулийн эхийг баригч учраас түүний үзэл санаа нь Үндсэн хуулийн үзэл баримтлалыг зөв тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой байна.

¹ Чимид.Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас - 60

II ТОВЧ АГУУЛГА

“Хууль дээдлэх ёсон бол засаг төр барих урлаг, хүн зон амар жимэр амьдрахуйн арга ухаан мөн” Б. Чимид

“Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гэсэн гуравдугаар бүлэг нь Үндсэн хуулийн агуулгыг бүхэлд нь илэрхийлж, Үндсэн хуулийн амин сүнсийг тодорхойлсон байх тул “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” бүтээлийн зорилго, үндсэн агуулгыг илэрхийлсэн байна.

“Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гэсэн гуравдугаар бүлэг нь:

- 1) Үндсэн хуулийн үзэл баримтлалыг судлахын учир
- 2) Төрийн бүрэн эрхт байдлын үндэс тулгуурын талаархи үзэл баримтлал
- 3) Хүний эрхийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлал
- 4) Төрийн байгууллын талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлал
- 5) Төрийн байгууламж, нэгжийн удирдлагын талаархи үзэл баримтлал гэсэн 5 дэд бүлгээс бүрдэж байна.

Энэхүү бүлэг нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгыг бүхэлд нь илэрхийлэхдээ зарим чухал хууль зүйн нэр томъёог тодорхойлж, Үндсэн хуулийн үзэл баримтлалыг зөв танин мэдэх боломжийг олгосон байгаа нь чухал ач холбогдолтой юм.

1992 оны Үндсэн хууль нь:

- Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт,
- Захиргаадалтын дэглэмээс ардчилсан дэглэмд

- Нэг үзэл суртлаас олон ургалч үзэлд,
- Нэг ангийн “ноёрхлоос” ард түмний засагт шилжих, улс төр, нийгэм, эдийн засаг, түүний мөн чанарыг шинэ хандлагаар хөгжүүлэх үзэл баримтлалыг агуулсан шинэ либерал хууль болохыг тодорхойлжээ.

“Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гэсэн гуравдугаар бүлэг нь Үндсэн хуулийн үндсэн агуулга, амин сүнсийг илэрхийлж төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, төрийн байгуулал, байгууламж, төр ба иргэн, хүний эрхийн талаархи үзэл баримтлалыг багтаасан байх тул зохиогчийн хэлсэнчлэн “Үндсэн хууль бол алганд багтсан Монгол Улс” болохыг нотолж байна.

III ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал бол орчин үеийн Үндсэн хуулийн үзэл санаа, онолд тулгуурлан, өмнөх үеийн Монголын төрт ёсны түүхэн хөгжил, Үндсэн хуулийн түүхэн сургамж, уламжлал шинэчлэлийг харгалзан бүтээгдсэн болох нь тодорхой илэрхийлэгдэж байна.

“Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гэсэн гуравдугаар бүлэгт судлаачийн байр сууриас дүн шинжилгээ хийхдээ шүүмжлэлт байдлаар дүн шинжилгээ хийсэнгүй, харин зохиогч шинэ Үндсэн хуулийн эхийг баригч учраас герменевтик арга зүйг ашиглан Үндсэн хуулийн үзэл баримтлалын агуулга, түүний амин сүнс, ач холбогдол, онцлогийг тодорхойлох дүн шинжилгээ хийсэн болно.

НЭГ. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг судлах зайлшгүй шалтгаан нь:

- 1) Үндсэн хуулийн агуулга нь гүнзгий, багтаамж нь агуу их,

- 2) Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага нь үндсээрээ шинэчлэгдсэн,
- 3) Үндсэн хуулийн үзэл баримтлал бол бусад хуулийг зөв боловсруулж, ойлгож, хэрэглэхийн анхдагч түлхүүр² болно.

ХОЁР. “Монгол Улсын төрийн бүрэн эрхт байдлын үндэс тулгуурын талаархи үзэл баримтлал” гэсэн дэд бүлэгт төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улс төр, нийгэм, эдийн засгийн үндсийг тодорхойлсон үзэл баримтлалыг тодорхой авч үзсэн нь Монголын төрийн амин сүнсийг зөв ойлгож, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Үүнд:

- 1) Ардчилсан улс орнуудын жишгийг харгалзан Монгол төрийн бүрэн эрхт, тусгаар тогтносон байдлын үндэс болсон суурь харилцаануудыг хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааны үүднээс тодорхойлжээ.
- 2) Төрийн бүрэн эрхт байдал гэдэг нь “тономол ардчилал” буюу аль нэгэн улс гүрнийг дагаж, ивээлд нь орших дагуул (сателитет)³ улсаас эрс ялгаатай⁴ бөгөөд Монгол Улс нь дэлхийн бусад улстай энх тайвнаар зэрэгцэн оршиж, хараат бус, бие даасан гадаад, дотоод бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж, “De facto” болон “De jure” –гийн хүрээнд бүрэн хэрэгжих явдал болохыг зохиогч өмнөх Үндсэн хуулиудын үзэл баримтлалтай харьцуулан, түүхэн сургамжийг эргэн сануулж, тодорхой жишээ фактад үндэслэн тодорхойлсон нь Монгол Улсын тусгаар

² Чимид.Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас - 60

³ Номын зохиогчийн тайлбар: 1990 –ээл оны эх хүртэл Монгол Улс “ЗХУ социалист систем”-ийн зохицуулсан бодлогыг дагаж, эдийн засгийн хувьд дан ганц ЗХУ –аас хараат байдалд орших төдийгүй, эх нутагт маань гадаад улсын хууль хүчин төгөлдөр үйлчилж ирсэнийг санах ахул төрийн бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын тухай заалт тунхаглалын төдий...юм. Чимид.Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас - 62

⁴ Чимид.Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас - 62

тогтнол, үндэсний аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашгийг хамгаалсан Үндсэн хуулийн үзэл баримтлал байх тул онол - практикийн чухал ач холбогдолтой байна. Тухайлбал, “Эрдэнэт” мэт хамтын үйлдвэрт ажиллагч бусад орны ажилтан, мэргэжилтний хөдөлмөр, цалин хөлсний нөхцөл, болзол адил ажил мэргэжлийн монгол ажилтныхаас илт давуутай байсан нь харьяалах улстай нь эрх тэгш бус гэрээтэй байсанд оршино”⁵ гэсэн энэхүү факт өнөөдөр ч Монгол Улсад ажиглагдан, хэвээр байгаа тул гажуудлыг арилгаж, улс орны бүрэн эрхт байдлыг хангах шаардлагатай юм.

- 3) Шинэ Үндсэн хуульд улс төрийн харилцааны асуудлыг “улс төрийн тогтолцоо” гэсэн нэгэн төвт, бүхэл цогц байх үзлээр хандаагүй, харин улс төрийн плюрализмын үзэл баримтлалд үндэслэн төрийн удирдлагын хэлбэр, засгийн эрх мэдэл, улс төрийн дэглэм, хүний улс төрийн эрх, эрх чөлөөний үүднээс тодорхойлсон тул өмнөх үндсэн хуулиас зарчмын ихээхэн ялгаатай бөгөөд Монголын улс төрийн харилцааны үндэс нь ард түмний засаглалд үндэслэсэн олон намт парламентат ёс⁶ болно.
- 4) Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1.1-д: “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэдгийг “механикаар тайлбарлаж болохгүй. Ард түмэн энэхүү эрхийг зөвхөн сонгуулийн өдөр хэрэгжүүлдэг гэсэн ойлголт биш, харин төрийн байгууллага, засгийн аливаа эрх тушаалтан ард түмнээс үүсч гараад, эргэж бүх шатандаа түүний хяналтад байж, өөрсдөд нь үйлчилдэг, тайлагнаж, хариуцлага хүлээдэг, итгэл хөсөрдүүлсэн хэнийг ч болов огцруулдаг ойлголт,

⁵ Мөн тэнд. хуудас - 63

⁶ Мөн тэнд. хуудас - 64

зарчимхамаарах”⁷ юм. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй ард түмнээс сонгогдсон элч сонгогчдын эсрэг эргэж хандваас дарангуйлал нүүрлэх аюултай⁸ учраас Улсын Их Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүд, тэдэнд үзүүлэх шахалт, хяналт Үндсэн хуулийн цэц, Улсын Их Хурлаар дамжуулан огцруулах эрх⁹, улс төрийн намууд, олон түмний хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба хяналтын бусад механизм, хариуцлагын бүхэл бүтэн тогтолцоо байгааг ойлгож, хэрэгжүүлэх нь чухал¹⁰ ажээ. Ийнхүү улс төрийн тогтолцооны үзэл баримтлалыг тодорхойлж, Германы сонгодог философич Гегелийн хэлсэнчлэн: “Төр бол ард түмний оюун санааны хүчний илрэл”¹¹ учир ард түмний оюун санааны илрэл, хүч болж чадахгүй байгаа төрийг огцруулах эрх нь ард түмэнд байгааг тодорхойлж өгсөн байна.

- 5) Шинэ Үндсэн хуулиар социалист нийгмийн “нэг намын удирдлага”, “ардчилсан төвлөн удирдах ёс” зэрэг тоталитар улс төрийн дэглэмийг халж, ардчилсан улс төрийн дэглэмийг хэрэгжүүлэх зорилгоор Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 1.1-т: Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заажээ. Төрийн үйл ажиллагааны энэхүү зарчмууд нь улс төрийн дэглэмийн мөн чанарыг илэрхийлсэн утга агуулга,

⁷ Чимид, Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас - 65

⁸ Мөн тэнд

⁹ Тайлбар Чимид Б.: Иргэд УИХ –ын гишүүнийг огцруулах үндэслэл байгаа эсэхийг тогтоолгохоор Үндсэн хуулийн цэцэд асуудал тавих эрхтэй.

¹⁰ Мөн тэнд

¹¹ Гегель, Г.В. “Собрание сочинении”. М. 1934. т- VIII. стр.268.

ач холбогдолтой болохыг тэмдэглэснийг анхаарах шаардлагатай¹² юм.

- 6) Мөн ардчилсан ёсны зарчим нь хууль дээдлэх, шударга ёсны зарчимтай салшгүй холбоотой тул нэгдмэл цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд “энэхүү шаардлагыг хангах нь улс төрийн ардчилсан дэглэмийг хэрэгжүүлэх гол арга зам”¹³ байхаас гадна эрх зүйт төрийг хэрэгжүүлэх механизм болохыг зөв ойлгож хэрэгжүүлэх шаардлагатай.
- 7) Үндсэн хуулийн эдийн засгийн харилцааны үндсийг Монгол Улсын тусгаар тогтнолын эдийн засгийн үндэс, дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлог, өмчийн харилцааны жам ёс, зах зээлийн эдийн засгийн үеийн төрийн чиг үүрэг, оролцооны үүднээс хандаж тодорхойлсон байна. Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 5.1-д: “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасан нь зохиогчийн хэлсэнчлэн: “Монголын эдийн засгийн харилцааг зөв төлөвшүүлэхэд аль нэг улсын загварыг хуулбарлан дагаж “далдганахгүй”, мөн “аль нэг улстай ойртон нягтрах”, “олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцох” зэрэг өрөөсгөл, хараат байдлаас ангид байж, харин дэлхийн эдийн засгийн хөгжлийн гол хандлагыг баримжаалж, өөрийн орны өргөн уудам нутаг, цөөн хүн ам, зуун зууны уламжлалт бэлчээрийн мал аж ахуй, байгалийн бага хөндөгдсөн эх нөөц, ажиллах хүчний хүрэлцээгүй байдал, хүн

¹² Тайлбар: Ардчилсан ёс (демократизм) гэдэг нь ардчилал (демократия) гэх ойлголтоос эх үндэстэй ч, утга санаа, агуулга багтаамжийн хувьд нарийн ялгаатай ажээ. Иймд ардчилсан ёс гэдэг нь ардчиллыг засаг төр, түүний байгууллагын үйл ажиллагаанд мөн чанараар нь ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон нарийн ойлголт гэж зохиогч үзэж, ардчиллыг тодорхойлох шинжийг тодорхойлсон байна.

¹³ Чимид Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас - 67

амын хэрэглээний хэр хэмжээ зэрэг онцлог, мөн хойч үеийнхээ язгуурын ашиг сонирхол зэргийг харгалзах зайлшгүй үзэл санаа агуулагдаж байна.¹⁴

- 8) Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 5.1-д: “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлагыг харгалзах” гэсэн заалтын өөр нэг агуулга нь “хувийн ба нийтийн өмчийн зөв зохистой харьцааны асуудал”-д нэн чухал учир холбогдолтой гэж үзсэнийг анхаарах шаардлагатай байна. Учир нь: зохиогч эдийн засгийн харилцаан дахь төрийн оролцоог үгүйсгэсэн хэт туйлширсан уламжлалт либерал үзлийг шүүмжилж, улс орны аюулгүй байдал, эдийн засгийн тусгаар тогтнол “эрхэмсэг оршихуй” -г үнэт зүйлийн үүднээс авч үзэж, “монголчууд бид төрөө юу ч үгүй шалдлахаас болгоомжилж, дэлхийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг “угтуулж” бодоход гэмгүй¹⁵ бөгөөд энэ нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үл харшилна”¹⁶ гэснийг зөв ойлгож, хэрэгжүүлэх шаардлагатай юм. Учир нь “Монгол Улсын Үндсэн хуульд зах зээлийн эдийн засаг төрийн зохицуулалттай байхыг тунхагласан бөгөөд уг оролцоог зорилго, чиглэлээр нь хязгаарлаж өгсөнд Үндсэн хуулийн үзэл баримтлалын ухаалаг тал оршин байна”¹⁷

- 9) Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 5.2-т: “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасан нь:

¹⁴ Мөн тэнд. Хуудас - 68

¹⁵ Тайлбар: Зохиогч энд дэлхийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг зөв танин мэдэж, улс орны эдийн засгийг өөрийн орны онцлог байдлыг харгалзан зөв хөгжүүлэх үзэл санааг илэрхийлсэн байна. Гэвч өнөөгийн Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг авч үзвэл, төрөө юу ч үгүй шалдлахаас гадна Монголын байгалийн баялагийг юу үгүй шалдлах нөхцлийг бүрдүүлж байгааг шүүмжлэн анхаарах шаардлагатай байна.

¹⁶ Чимид, Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас - 69

¹⁷ Мөн тэнд.

- a) Нийтийн ба хувийн гэсэн хоёр төрлийн өмчийн бүхий л хэлбэрийг хүлээн зөвшөөрсөн нь эдийн засгийн олон хэвшил, тэдгээрийн шударга өрсөлдөөнд үндэслэсэн зах зээлийн эдийн засгийн харилцаа бүрэлдэнэ,
- b) Нийтийн (төрийн, орон нутгийн, шашин – сүм хийдийн, нам – холбооны, олон түмний /массын/ гэх мэт) ба хувийн (хувь хүний, гэр бүлийн, хэсгээр /хувьцаалсан/ болон хамтран өмчлөх дундын зэрэг) өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэсэн агуулгатай бөгөөд Үндсэн хуулийн эдийн засгийн үндсийг тодорхойлсон өргөн агуулгатай ажээ.
- 10) Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 5.4 -т: “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан нь:
- 1) Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал,
 - 2) Аж ахуйн бүх хэвшлийн хөгжил,
 - 3) Хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцсэн байхыг заасан төрийн эдийн засгийн бодлогын томоохон гурван чиглэл юм.
- 11) “Хүний жам ёсны эрх – өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрсөн нь Үндсэн хуулийн үнэт зүйлсийн нэг мөн” бөгөөд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 –д заасан ёсоор Монгол Улсын иргэд хөдлөх төдийгүй үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй болсон нь нийгмийн эдийн засгийн харилцааны амин судас мөн¹⁸ байна.

¹⁸ Чимид.Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас – 69 - 70

12) Монголчууд Модун Шанью-гийн үеэс “газар бол хүний амьдралын үндэс” хэмээн үзэж, газрыг иргэнд зөвхөн эзэмшүүлэн ашиглуулж ирсэн бөгөөд иргэнд газрыг өмчлүүлж байгаагүй юм. Харин Монгол Улсын хувьд түүхэндээ анх удаа шинэ Үндсэн хуулиар газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлэх эрхийг Үндсэн хуулиар олгосон боловч “газар бол хууль зүйн тусгай хязгаарлалт¹⁹ бүхий өмч²⁰ учраас ихээхэн онцлогтой”²¹ юм. Иймд Монгол Улс дахь газар өмчлөх хувийн өмч нь бусад улс орны газрын болон манай орны эдийн баялгийн бусад эд юмсыг өмчлөхөөс зарчмын ялгаатайг зохиогч онцгойлон тэмдэглэснийг анхаарч, Үндсэн хуулийн үзэл баримтлалын үүднээс зөв хэрэгжүүлэх шаардлагатай байна.

13) Зохиогч “Нийгмийн эдийн засгийн харилцааны үндэс нь бүхэлдээ төрийн тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөөт байдлын баталгаа болохын хувьд төрийн үүрэг, хүний эрхийн уулзварт огтлолцдог зангилаа асуудлын нэг мөн” хэмээн үзэж, угтаа “Төр өмчийнхөө

¹⁹ Зохиогчийн тайлбар: Газар өмчлөх хууль зүйн тусгай хязгаарлалт нь:

- Газар өмчлөгч зөвхөн Монгол Улсын иргэн байна гэсэн субъектын хатуу хязгаарлалттай. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монголд газар өмчлөх эрх эдлэхгүй.
- Хувьд өмчилж болох газрын сангийн хувьд хязгаарлалттай. Бэлчээр, нийтийн болон тусгай хэрэгцээний газрыг хувь хүн өмчлөхийг Үндсэн хуулиар хориглосон. Монгол Улсын 156 сая га газрын дийлэнхи нь буюу 90 гаруй хувь нь төрийн өмчлөл байх тооцоо бий.
- Үндсэн хуульд зааснаар “Газар өмчлөх нь газрын хэвлийд хамаарахгүй”. Өөрөөр хэлбэл, газрын хэвлий, түүний баялаг нь төрийн онцгой өмч хэвээр байна.
- Газар өмчлөх эрхээ Монголын өөр иргэнд шилжүүлэх явдал улсын бүртгэл хяналтанд байна.
- Төрөөс газрын эзэнд зөвхөн өмчилж байгаа газартай нь холбогдсон үүрэг, өөрөөр хэлбэл, газар өмчлөгчийнх нь хувьд орчны баялгийг хамгаалах, ургацаа улсад худалдах гэх мэт тусгай үүрэг хүлээлгэж болно.
- Төр хувийн өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээнд зориулан нөхөх олговортойгоор сольж буюу үнэ төлбөргүйгээр эргүүлэн авах эрхтэй.
- Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авах хязгаарлалттай болно.

²⁰ Зохиогчийн тайлбар: “Өмч гэдэг нь...өдөр тугмын хэрэглээний ердийн эд хогшил төдий биш, юуны өмнө капиталын эх үүсвэр болсон үл хөдлөх эд хөрөнгийг олж авч ноёрхлоо бүрэн тогтоож, улмаар түүнийгээ насан туршдаа эзэмдэж, захиран зарцуулах, эцсийн бүлэгт удам хойчдоо өвлүүдэх эрх боломжийг хангасан эдийн засгийн харилцаа” Чимид.Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас – 71

²¹ Чимид.Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас – 71

эзэн байж чадах уу?”, “Хувийн өмчийг хамгаалан дэмжигч байж чадах уу?”, “Энэ хоёр төрлийн өмчийг сүлэн завшигчийн эсрэг ухаалаг тэмцэгч байж чадах уу?” гэсэн гурван бүлэг асуултыг төв, орон нутгийн эрх баригчдын өмнө Үндсэн хууль тавьсаар байгаа юм” гэж тусгайлан тэмдэглэжээ. Энэхүү асуулт одоо ч тавигдаж байгаа бөгөөд эерэг бус, сөрөг хариулт байгаа нь хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэх шаардлагыг илэрхийлж байна.

- 14) Өмнөх Үндсэн хуулиудад нийгмийн харилцааны үндсийн ангийн бүтцийн үүднээс тодорхойлж байсан бол 1992 оны Үндсэн хуульд төрийн нийгэмшлийн үндсийг “ард түмэн” гэсэн үзэл баримтлалын үүднээс тодорхойлсноор онцлог байна.
- 15) Оюун санааны хүрээнд “социалист үзэл суртал”-аас нийгмийн олон ишт үзлийг үндсээ болгож, оюун соёлын харилцааны чөлөөт байдлыг бататгасан нь Үндсэн хуулийн нэг үзэл баримтлал юм.

ГУРАВ. “Хүний эрхийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлал” дэд бүлэгт Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн үзэл баримтлалыг тайлбарласан нь онол – практикийн ач холбогдолтой байна. Тухайлбал,

- 1) Хүний эрхийн тухай үзэл санаа эртнээс үүссэн боловч, хүн төрөлхтний түүхэнд хожуу дэлхийн II дайны дараа биеллээ олж хэрэгжих болсныг түүхэн үүднээс судлан авч үзэж, хүний эрх ба иргэний эрх, эрх чөлөөний ялгааг²² гаргаж, улмаар Үндсэн хууль дахь хүний эрхийн үзэл баримтлалыг тодорхойлсон байна.

²² Зохиогчийн тайлбар: “Хүний эрх” -ийн ойлголт нь “иргэний эрх, эрх чөлөө” –ний ойлголттой ихээр давхцдаг боловч ялгаатай ойлголт юм. “Хүний эрх” гэдэг бол даяаршсан ойлголт, тухайн улсын иргэн, гадаад улсын харьяат хийгээд харьяалалгүй хүмүүсийг нийтэд нь багтаасан ухагдахуун. “Иргэний эрх” гэдэг бол тухайн улсын харьяатын эрх, эрх чөлөөг хамарсан бөгөөд “хүний эрх” гэсэн их ухагдахуунд багтсан ойлголт болно. Чимид. Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас – 77

- 2) Өмнөх Үндсэн хуулиудад хүний эрхийг тунхаглан баталгаажуулаагүй, хүн амын нэг хэсгийг ялгаварлан гадуурхаж, иргэний эрхийн асуудлыг зарчмын өөр байр сууриас тусгасныг тэмдэглэж, харин “1992 оны Үндсэн хуульд “хүний эрх” гэдэг их ухагдахуунд “иргэний эрх” гэдэг бага ухагдахууныг багтаан тодорхойлох замаар хүний эрхийн үндсэн зарчмуудыг хүлээн зөвшөөрч, тэр үндсэн дээр харьяат иргэдийнхээ үндсэн эрх, эрх чөлөө, түүнийг хангах баталгаа, гол механизмыг бататган бэхжүүлсэн явдал нь нэг онцлог”²³ байна.
- 3) Мөн Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг тодорхойлохдоо аль нэгэн улсын хуулийг хуулбарлан дагасангүй, харин олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн ухамсарлаж, дэлхийн бусад улс орны жишгийг харгалзаж, Монгол Улс туурга тусгаар, бүрэн эрхт улс мөн болохыг иш үндэс болгосон байна.
- 4) Иргэдийн улс төр, нийгэм, эдийн засгийн эрх, эрх чөлөө нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 зүйл заалтаар хязгаарлагдахгүй, 16 дугаар зүйл тус бүрт олон эрхийг тусгаснаас гадна Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нэмэгдэж байгааг тодорхойлсон нь Үндсэн хуулийн үндсэн хуульт ёсны шинжийг илэрхийлсэн байна.
- 5) Монгол Улс нь бүрэн эрхт улс учир манай оронд буй гадаад улсын иргэний эрх зүйн байдлыг Монгол Улсын хууль ба харьяалах улстай байгуулсан хоёр талын гэрээгээр тодорхойлж, улс хоорондын “харилцан адил байх” зарчмыг хэрэглэх, харин харьяалалгүй хүний эрх зүйн байдлыг хуулиараа тогтоож байх эрхийг төр өөртөө хадгалан үлдээсэн нь үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдал, улсын язгуур эрх ашигтай холбоотой ажээ.

²³ Чимид, Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас – 80

- 6) Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т: “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж хүний үндсэн эрхийг ямар ч нөхцөлд, түүний дотор дайн байлдаан, онц байдлын нөхцөлд ч хязгаарлахыг хориглож, жам ёсны эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан нь либерал Үндсэн хууль болохыг илэрхийлж байна.
- 7) Хүний эрхийг хамгаалах, хангах баталгааг бүрдүүлэх үүргийг төрд оногдуулсан нь үндсэн хуульт ёсны нэг шалгуурыг хангасан гэж дүгнэж болно.
- 8) Хүн бүр эрх зүйн этгээд болохын хувьд, хууль, шүүхийн өмнө адил тэгш эрхтэй байж, хуулиар хориглоогүй бүхнийг хийх эрхтэй бөгөөд хүний эрхийг гагцхүү хуулиар хязгаарлаж болохыг Үндсэн хуулиар тогтоосноос гадна төр, түүний байгууллага, албан тушаалтан хуульд заасан эрх хэмжээний дотор буюу илүү хязгаарлагдмал эрхтэй байхыг хуульчилж эрх зүйт төрийн шинжийг илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл, иргэний хувьд хориглосноос бусад нь зөвшөөрөгдсөн бол төр, түүний албан тушаалтны хувьд зөвшөөрснөөс бусад нь хориглосон²⁴ гэсэн агуулгатай болохыг төрийн албан тушаалтнууд ойлгож, хэрэгжүүлэх нь үндсэн хуульт ёсны нэг шалгуур гэж үзэж байна.

²⁴ Чимид Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас – 85

ДӨРӨВ. “Төрийн байгууллын талаархи үзэл баримтлал” гэсэн дэд бүлэгт төрийн үйл ажиллагааны болон зохион байгуулалтын зарчим нь төрийн байгууллын үзэл баримтлал болсныг тодорхойлсон байна. Үүнд:

- 1) Юуны өмнө төрийн байгуулал, төрийн байгууллага, төрийн байгууламж гэсэн нэр томъёо нь агуулгын ялгаатай болохыг тодорхойлсон нь²⁵ хууль зүйн техникийг хөгжүүлсэн сайн талтай юм.
- 2) Төрийн улс төрийн ардчилсан дэглэмийн үзэл баримтлал нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 1.2 –т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан төрийн үйл ажиллагааны зарчмаар тодорхойлогдож байна.
- 3) Эртний Грекээс үүсэлтэй төрийн эрх мэдлийг хуваарилах онол нь төрийн байгууллын зохион байгуулалтын суурь зарчим болсон байна.
- 4) Өмнөх Үндсэн хуулиуд төрийн эрх мэдлийг хэлбэрийн хувьд Хурлуудад, хэрэг дээрээ нэг намын гарт төвлөрүүлж, нэгдмэл төвлөрсөн “босоо” удирдлагатай байсан нь төрийг иргэний нийгмийн хяналтаас гаргаж, хүний эрхийг зөрчихөд хүргэсэн²⁶ гэсэн зохиогчийн үзэл санааг зөвшөөрч, энэхүү түүхэн сургамжийг давтахгүй байхыг анхаарах шаардлагатай.

²⁵ Зохиогчийн тайлбар: “Төрийн байгуулал гэдэг нь төрийн зохион байгуулалт, үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан бөгөөд агуулга, хэлбэрийг илэрхийлсэни их ухагдахуун. Түүнд төрийн чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим, төрийн байгууллагын тогтолцоо, түүний салаа мөчрийн эрх зүйн байдал зэрэг гол гол язгуур махбод багтана. Төрийн байгууллага гэдэг бол ...нийтийн эрх зүйн субъект мөн. Төрийн байгууламж гэдэг нь улсын бүтцийн асуудлыг хамаарна” Чимид. Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн очил). УБ. 2006 он. Хуудас – 86

²⁶ Мөн тэнд. Хуудас - 89

- 5) 1992 оны Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд²⁷ хуваарилсан нь үндсэн хуульт ёсны илрэл гэж дүгнэж байна.
- 6) Гэхдээ төрийн эрх мэдлийг Үндсэн хуульд тусгасан гэснээр үндсэн хуульт ёс хэрэгжихгүй болохыг зохиогч анхааруулж, эрх мэдлийг зөв хэрэгжүүлэх арга замыг тодруулан тогтоож, түүнийг төрийн байгууллага, албан тушаалтны ой ухаан, арга барилд бат шингээж, улмаар дадал болгох, нийтийн засаглалын байгууллагууд хэрхэн баримталж буйд иргэний нийгмийн болон шүүхийн хүчтэй хяналт тогтоож, аливаа гажуудлаас сэргийлэх оновчтой арга хэрэглүүр нэвтрүүлэх нь чухал²⁸ гэснийг онолын үүднээс төдийгүй практикийн үүднээс зөв хэрэгжүүлэх шаардлагатай юм.
- 7) Мөн төрийн эрх мэдлийн (power) ажил, үүрэг, хариуцлагын хуваарилалтыг захирах гэсэн засаг (власть), засаглал (властвование) гэсэн ойлголттой адилтгаж, агуулгыг нь төөрөгдүүлж байгааг зохиогч шүүмжилж, энэхүү зохион байгуулалтын зарчим нь “төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаа, түүний хэлбэрт энэ зарчим илэрч хэрэгжих ёстой тул эрх мэдлийг хольж хутгаж, нэгийг нь нөгөөтэй нь хавсруулбал хүний эрх, эрх чөлөөнд хор аюултай болохыг эрх мэдлийг хуваарилах онолыг үндэслэгчид өгүүлж байсныг сануулж, Үндсэн хуулийн үзэл баримтлалыг “хоосон тунхаглал”, төдийгүй ноцтой зөрчил гажуудлын халхавч болж үлдэх аюултайг санацгааж явбал өлзийтэй”²⁹ гэж зохиогч анхааруулсан нь одоо ч үнэ цэнэтэй хэвээр байна.

²⁷ Тайлбар:Төрийн эрх мэдлийн (power) ажил, үүрэг, хариуцлагын хуваарилалтыг захирах гэсэн засаг (власть), засаглал (властвование) гэсэн ойлголттой адилтгаж, агуулгыг нь төөрөгдүүлж байгааг зохиогч шүүмжилжээ.

²⁸ Чимид Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас – 90

²⁹ Мөн тэнд, хуудас - 94

- 8) Дээрхээс үндэслэн, Үндсэн хуулийн үзэл баримтлалын үүднээс төрийн эрх мэдлийн:
- a) чиг үүргийн /хууль батлах, хэрэгжүүлэх, хэрэглэх тайлбарлах/,
 - b) институцийн /гурван чиг үүргийг өөр байгууллагад хуваарилах/
 - c) хүн хүчний /эдгээр байгууллагад ажиллах хүмүүс нь давхцахгүй байх/ гэсэн ангиллыг төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмын үүднээс зөв хэрэгжүүлэх нь төрийн үүрэг бөгөөд улс төрийн гажуудлыг арилгаж, үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэх арга зам гэж дүгнэж байна.

ТАВ. “Төрийн байгууламж, нэгжийн удирдлагын талаархи үзэл баримтлал дэд бүлэгт” төрийн байгууламж, түүний үзэл баримтлалыг ерөнхийгөөс нэгжийг тодорхойлох аргаар тодорхойлжээ. Үүнд:

- 1) Төрийн байгууламж нь тухайн улсын бүтцийг илэрхийлдэг учраас Монгол Улсын хувьд нутаг дэвсгэр нь зөвхөн төв засгаас тогтоосон статустай, засаг захиргааны нэгжүүдэд хуваагдсан нэгдмэл улс болох тул Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн 2.1 –д: “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна”, 2.2-т: “Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана” гэж заасан байна.
- 2) Засаг захиргаа - нутаг дэвсгэрийн хуваарилалтыг өмнөх үеийн уламжлал, өнөөгийн шинэчлэлийг харгалзан Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 –д: Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана” гэж дээд,

суурь, язгуур гурван нэгжийн бүрдүүлбэртэй³⁰, хүн ам, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгэн бүхэл нэгдмэл улс болохыг заажээ.

- 3) Хот, тосгон, түүний удирдлага нь засаг захиргаа – нутаг дэвсгэрийн бус, харин засаг захиргаа – нутаг дэвсгэр дэх бие даасан статустай болохыг тогтоосон нь Үндсэн хуулийн нэг гол үзэл баримтлал юм.
- 4) Мөн аймаг, сум нь нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгэмшлийн үндэстэй, өөрийн удирдлага бүхий Үндсэн хуулийн эрх зүйн статус бүхий өөрийн засаг захиргааны бүтэц, үүрэгтэй, бие даасан субъект байх буюу “нутаг дэвсгэрийн хамт олон” бие даан хөгжих эрхийг тунхагласан, төрөөс орон нутаг, засаг захиргаа – нутаг дэвсгэрийн нэгж, тэндхийн иргэний нийгэмтэй харилцан ажиллах гол үзэл баримтлал³¹ ажээ. Баг, хороо нь эдийн засгийн хувьд бие даасан эрхгүй боловч, нийтийн эрх зүйн буюу засаг захиргааны харилцаанд харьцангуй бие даасан статустай байна.
- 5) Засаг захиргаа – нутаг дэвсгэрийн шинэтгэлийг хийхэд 10 гаруй үндэслэл шаардлагыг харгалзаж³², шинжлэх ухааны үндэслэл, зарчмыг баримталж, төвлөрөл ба эс төвлөрөл хоёрын харьцааг зөв тогтоон, орон нутгийн нэгжийн бие даах хэвтээ тогтолцоонд оруулан, өөрөө удирдах ёс болон төрийн удирдлагыг хослуулах аргаар төр, ард түмний бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах нь Монгол Улсын төрийн байгууламжийг бататгасан Үндсэн хуулийн гол үзэл баримтлал болохыг зохиогч тодорхойлсон нь үнэ цэнэтэй байна.

³⁰ Чимид, Б. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). УБ. 2006 он. Хуудас – 99 - 101

³¹ Мөн тэнд, хуудас – 101 - 102

³² Мөн тэнд, хуудас – 103 - 105

IV ДҮГНЭЛТ

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б. Чимидийн “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” номын “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” гуравдугаар бүлгийг судлан дүн шинжилгээ хийсний үр дүнд дараахи дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” бүлэг нь Үндсэн хуулийн агуулга, амин сүнснийг тодорхойлсон байх тул нэг судлаачийн судалгаа, дүгнэлтээр агуулга нь бүрэн тодорхойлогдохгүй бөгөөд зохиогчийн хэлсэнчлэн “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй”- н “сав нь их, санаа нь шавхагдашгүй” тул цаашид улам гүнзгийрүүлэх судлах шаардлагатай юм.

2. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” номын “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй” бүлэгт Үндсэн хуулийн үзэл баримтлалыг эрх зүйн шинжлэх ухааны онол – арга зүйн үүднээс тодорхойлон гаргаснаас гадна хууль зүйн нэр томъёог тайлбарласан явдал нь хууль зүйн техникийн хөгжилд ихээхэн хувь нэмрийг оруулж байна.

3. Зохиогч энэхүү бүтээлийг ихэс дээдэс, хүн бүрт зүгээр ч нэг хандаж бүтээгээгүй, харин Үндсэн хуулийн үзэл санааг зөв ойлгож, зөв хэрэгжүүлэхийг зорьсон учраас Үндсэн хуулийн үзэл баримтлалыг сурталчлан таниулж, төрийн албан хаагчид, улс төрчид, ард иргэдэд Үндсэн хуулийн мэдлэг олгох замаар эрх зүйн ухамсар, соёлыг төлөвшүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

4. “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” ном нь Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд төдийгүй эрх зүйн шинжлэх ухааныг онол – практикийн үүднээс хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байна.

5. Эцэст нь, “Үндсэн хууль бол алганд багтсан Монгол Улс” учраас төр, ард түмний бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдал, иргэн, хүний эрхийг хангаж, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх субъект болох төрийн албан хаагчид, улс төрчид Үндсэн хуулийн үзэл баримтлалаар амьсгалах үүрэгтэй болохыг зохиогч зориуд тэмдэглэсэн нь Монгол Улсад төрт ёсны үнэт зүйл болох үндсэн хуульт ёсыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.